

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 12 дугаар
Сарын 17-ны өдрийн 443 дугаар тогтоолын хавсралт

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

ТАЙЛАНГИЙН ЭХНИЙ ХЭСЭГ.....	3
ТАЙЛАНГИЙН ХОЁРДОХ ХЭСЭГ	6
ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ	
УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.....	8
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА / БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	8
ЭРХЭМ ЗОРИЛГО.....	9
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД.....	10
ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	11
БРОКЕР, ДИЛЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	11
ХАРИЛЦАГЧИД.....	12
БОНДЫН АРИЛЖАА.....	13
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ, СУДАЛГАА.....	14
АНДЕРРАЙТЕРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	15
ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ.....	18
САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	19
ХӨРӨНГӨ БҮРЭЛДЭХҮҮН.....	20
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ.....	21
ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГ	21
САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ.....	22
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН.....	23
НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА.....	29
ТАЙЛАНГИЙН ГУРАВДУГААР ХЭСЭГ.....	31

I. ТАЙЛАНГИЙН ЭХНИЙ ХЭСЭГ

1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг:

“БиДиСЕК ҮЦК” Хувьцаат Компани

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Залуучуудын өргөн чөлөө-27/1, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо

Утас: 11-321763

Факс: 11-321763

Электрон хаяг: www.bdsec.mn

2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл:

Улсын бүртгэлийн дугаар: 9010001030

Регистрын дугаар: 2052482

Үйл ажиллагааны чиглэл: Брокер дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 420 /2016 оны 03-р сарын 28-ны өдрөөр/

3. Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл:

Эрхэм зорилго: Үндэсний үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн цогц үйлчилгээгээр дэмжих, олон улсын стандартанд нийцсэн санхүүгийн зах зээлд тэргүүлэгч байгууллага болох.

4. Үнэт цаас гаргагчийн түүх, тухайн зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа:

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн үйл ажиллагаа Монгол Улсад Хөрөнгийн Зах Зээл үүссэн 1991 оноос эхэлсэн бөгөөд өдгөө 26 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж буй тус салбарын ууган компаниудын нэг юм.

БиДиСЕК ҮЦК нь Монголын Хөрөнгийн зах зээл дээр Андеррайтер, Брокер, Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг гадаад дотоодын харилцагчид, түнш байгууллагууддаа цогцоор нь чанарын өндөр түвшинд үзүүлж, урт хугацааны итгэлтэй түншлэлийн харилцааг эрхэмлэн ажиллаж ирсэний үр дүнд дотоодын Хөрөнгийн зах зээлийн тэргүүлэгч компани болж чадсан.

Энэ бүхнийг манай компанийн үйлчилж буй харилцагчидын тоо, үнэт цаасны арилжааны хэмжээ, гаргасан IPO, санхүүгийн чадвар, тогтвортой байдал, харилцагчиддаа үзүүлдэг үйлчилгээний төрөл зэрэг олон үзүүлэлтүүд илтгэдэг.

Монголын хөрөнгийн зах зээл дээр нийт 20 компанийн “IPO” хийгдсэн бөгөөд “БиДиСЕК ҮЦК” ХК нь үүний 42 хувьд андеррайтераар ажилласан байдаг. Нэмэлтээр гаргасан үнэт цаасны “FPO”-ийн 71 хувьд, нийт гаргасан компанийн бондын 33 хувьд тус тус андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн.

2015 оны жилийн эцсийн байдлаар үнэт цаасны зах зээлд оролцох данстай харилцагчдын тоо, нийт зах зээлийн харилцагчдын 25 хувь буюу 200,000 гаруй харилцагчтай болсон.

5. Үнэт цаас гаргагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гаргасан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл:

“БидиСЕК ҮЦК” ХК-ийн үндсэн бизнес нь Монголын хөрөнгийн зах зээл дээрээс гадаад дотоодын хөрөнгө оруулагчид үнэт цаас худалдан авахад зуучлал /брокер/, аж ахуй нэгжүүдэд үнэт цаас гарган хөрөнгө оруулалт татах андеррайтерийн үйл ажиллагаа юм.

Мөн биржид компаниуд шинээр бүртгүүлэх, бүртгэлтэй хувьцаат компаниудын засаглалыг сайжруулах, үр ашиг бүхий төсөлд хөрөнгө оруулалт татах, иргэдэд үнэт цаасны арилжаанд оролцоход Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг үзүүлдэг.

Эдгээр үйлчилгээнүүдийн манай компанийн салбартаа олон жил ажилласан туршлагатай, чадварлаг удирдлага, зөвлөх мэргэжилтнүүд Монгол Улсын хууль тогтоомж, зохицуулах байгууллагуудын дүрэм журамд нийцүүлэн чанарын өндөр түвшинд үзүүлж байна.

1. Брокерийн үйл ажиллагаа: “БидиСЕК ҮЦК” ХК нь харилцагч, хөрөнгө оруулагчдад Монголын Хөрөнгийн зах зээл дээрээс үнэт цаас худалдан авах, худалдах захиалгыг зуучлалын үйл ажиллагаа буюу брокерийн үйлчилгээг дамжуулан түргэн шуурхай гүйцэтгэж байна.

- a. Төл И брокер
- b. Арилжааны танхим
- c. Сургалт зөвлөгөө
- d. Мэдээлэл, судалгаа
- e. Хөрөнгө оруулагчдын уулзалт
- f. Багцын арилжаа
- g. Бусад нэмэлт үйлчилгээнүүд

2. Андеррайтерийн үйлчилгээ: Бид андеррайтерийн үйл ажиллагааны хүрээнд санхүүжилт шаардлагатай байгаа компанийн үнэт цаасыг хаалттай болон нээлттэй хүрээнд хөрөнгө оруулагчдад зуучлан борлуулах, зарим тохиолдолд үнэт цаасыг нь анхдагч зах зээл дээрээс бүхлээр нь болон хэсэгчлэн худалдан авах, үнэт цаасны бүртгэлийн болон анхдагч зах зээлийн арилжааг удирдан зохион байгуулан ажилладаг.

- a. Хувьцаагаар санхүүжилт татах
 - i. Шууд хөрөнгө оруулалт
 - ii. Шинээр хувьцаа гаргах буюу IPO
 - iii. Давуу эрхийн хувьцаа
 - iv. Нэмэлт хувьцаа гаргах буюу FPO
- b. Зээлийн санхүүжилт
 - i. Хаалттай бонд
 - ii. Нээлттэй бонд
 - iii. Хөрвөх зээл
 - iv. Хөрвөх бонд

3. Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ: Манай компани 2007 онд “Санхүүгийн Зохицуулах Хороо”-ноос Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх эрхийг авсанаар үнэт цаасанд хөрөнгө оруулах сонирхолтой хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагад хөрөнгө оруулалт хийхэд нь зөвлөх, санхүүжилт шаардлагатай байгаа компаниудад хөрөнгийн зах зээл дээрээс санхүүжилт татах боломжийн талаар зөвлөгөө өгөн ажиллаж байна.

- a. Иргэдэд зориулсан цогц үйлчилгээ
- b. Аж ахуйн нэгжүүдэд зориулсан үйлчилгээ
- i. Тендер санал зарлах
- ii. Компанийн хэлбэрийг өөрчлөх
- iii. Хувьцаа эзэмшигчдийн хурал
- iv. Санхүүжилт татах
- v. Компанийн засаглалын зөвлөгөө зэрэг үйлчилгээнүүдийг харилцагч байгууллагуудад хүргэж байна.

6. Үнэт цаас гаргагчийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл:
Компанийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Д.Даянбилгүүн	Гүйцэтгэх захирал	19.58%
2	Б.Лхагвадорж	Тэргүүн дэд захирал	3.68%
3	Н.Батгэрэл	Дэд захирал	2.57%
4	Firebird MF Holdings S.A.R.L	-	6.50%
5	Firebird Global Master Fund Holdings-1 S.A.R.L	-	5.23%
6	Firebird GM 2 S.A.R.L	-	7.70%
7	Impera Mongolia Holdings Ltd	-	5.40%
8	Alexander Zwahr	-	22.84%

7. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга:

№	Овог нэр	Албан тушаал	Боловсрол
1	Д.Даянбилгүүн	Гүйцэтгэх захирал	Дээд
2	Б.Лхагвадорж	Тэргүүн дэд захирал	Дээд
3	Н.Батгэрэл	Дэд захирал	Дээд
4	Nick Cousyn	Үйл ажиллагаа хариуцсан захирал	Дээд
5	James Passin	ТУЗ-ийн гишүүн	Дээд
6	Д.Амгаланбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд
7	Hitoshi Tani	ТУЗ-ийн гишүүн	Дээд
8	Б.Энхбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд
9	Б.Амарсанаа	ТУЗ-ийн гишүүн	Дээд
10	Philip Houry	ТУЗ-ийн гишүүн	Дээд
11	Ө.Даваасүрэн	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Дээд
12	С.Пүрэвсүрэн	Дотоод албаны менежер	Дээд
13	М.Цагаанцэцэг	Ерөнхий нягтлан бодогч	Дээд
14	Г.Мөнхтулга	Институциональ харилцагчийн албаны менежер	Дээд
15	Ш.Шинэбаяр	Хөрөнгө оруулалтын албаны менежер	Дээд
16	О.Уранбайгаль	Back Office менежер	Дээд

8. Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл:

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Д.Даянбилгүүн	Гүйцэтгэх захирал	19.58%
2	АНУ-н хөрөнгө оруулалтын сан	-	19.43%
5	Impera Mongolia Holdings Ltd	-	5.40%
6	ХБНГУ-н хөрөнгө оруулагч	-	22.84%

II. ТАЙЛАНГИЙН ХОЁРДАХЬ ХЭСЭГ

1. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт:

Компанийн 2013, 2014, 2015 оны орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:
/мян.төг/

Үзүүлэлт	2014 он	2015 он*	2016 он*
Борлуулалт	2,158,871	797,159	879,635
Борлуулалтын хөнгөлөлт	-	-	-
Цэвэр борлуулалт	2,158,871	797,159	879,635
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,259,413	-	-
Нийт ашиг	899,458	-	-
Үйл ажиллагааны зардал	1,717,312	(1,316,319)	(1,501,327)
Үйл ажиллагааны ашиг /алдагдал/	676,898	(397,675)	(500,476)
Үйл ажиллагааны бус зардал	(36,228)	(25,088)	(85,915)
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	535,201	26,470	(705,448)
Орлогын татварын зардал	50,479	(6,945)	(5,065)
Цэвэр ашиг /алдагдал/	(484,722)	19,526	(710,514)

* -Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа явуулах этгээдэд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн загварын дагуу

Компанийн 2014, 2015, 2016 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

/мянган төгрөгөөр/ Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлтүүд	2014 он	2015 он	2016 он
Эргэлтийн хөрөнгө	11,200,287	9,218,669	9,168,401
Эргэлтийн бус хөрөнгө	3,527,369	6,497,853	5,556,013
Нийт хөрөнгийн дүн	15,716,523	14,727,657	14,724,414
Богино хугацаат өр төлбөр	1,538,653	441,528	138,200
Урт хугацаат өр төлбөр	-	-	-

2. Компани нь 2016 оны жилийн эцсийн байдлаар 1,434.89 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай байгаа ба өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс их байна.

3. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээр нь үнэт цаас эзэмшдэг талаарх мэдээлэл:

№	Овог нэр	Цалин урамшуулалын хэмжээ /жил/	Хандив тусламжийн тоо	Бусад	Эзэмшиж буй хувьцааны хэмжээ
1	Б.Лхагвадорж	6,000,000	-	-	3.68%
2	Д.Даянбилгүүн	6,000,000	-	-	19.58%
3	Н.Батгэрэл	6,000,000	-	-	2.57%
4	James Passin	6,000,000	-	-	-
5	Д.Амгаланбаяр	6,000,000	-	-	2.43%
6	Hitoshi Tani	6,000,000	-	-	2.26%
7	Б.Энхбаяр	6,000,000	-	-	0.001%
8	Б.Амарсанаа	6,000,000	-	-	-
9	Philip Houry	6,000,000	-	-	-

4. Ногдол ашгийн талаарх мэдээлэл:

“БиДиСЕК ҮЦК” ХК нь 2006 оноос хойш нийтдээ 6 удаа хувьцаа эзэмшигч нартаа ногдол ашиг тараасан ба 2013 онд нэгж хувьцаанд 11.78 төгрөг, 2012 онд нэгж хувьцаанд 60 төгрөг, 2010 онд нэгж хувьцаанд 50 төгрөг, 2008 онд нэгж хувьцаанд 5 төгрөг, 2007 онд нэгж хувьцаанд 30 төгрөг, 2006 онд нэгж хувьцаанд 3 төгрөгийг тус тус тараасан болно.

5. Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаарх мэдээлэл:

“БиДиСЕК ҮЦК” ХК нь 2015 онд “Компанийн тухай хууль”-ийн 87 зүйлд заасан их хэмжээний хэлцэл хийгээгүй болно. Мөн “Компанийн тухай хууль”-ийн 89 дүгээр зүйлд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй болно.

6. Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын үйл ажиллагааны тайлан:

№	Овог нэр	Эрхэлдэг ажил	Эзэмшсэн боловсрол мэргэжил	Эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь	Хараат бус гишүүн эсэх
1.	Б.Лхагвадорж	ТУЗ-ийн дарга	Дээд, нефтийн инженер	3.68%	Хараат
2.	Д.Даянбилгүүн	ТУЗ-ийн гишүүн	Дээд, Бизнесийн удирдлага	19.58%	Хараат
3.	Н.Батгэрэл	ТУЗ-ийн гишүүн	Дээд, Гадаад харилцаан	2.57%	Хараат
4.	James Passin	ТУЗ-ийн гишүүн	Дээд	-	Хараат
5.	Philip Khoury	ТУЗ-ийн гишүүн	Дээд	-	Хараат
6.	Д.Амгаланбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд	2.43%	Хараат бус
7.	Hitoshi Tani	ТУЗ-ийн гишүүн	Дээд	2.26%	Хараат бус
8.	Б.Энхбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд	0.001%	Хараат бус
9.	Б.Амарсанаа	ТУЗ-ийн гишүүн	Дээд	-	Хараат бус

Компани нь 2015 оны 03-р сарын 26-ны өдөр “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг зарлан хуралдуулж, ТУЗ-ын гишүүдийг дахин сонгосон бөгөөд 2015 оны 05-р сарын 08-ний өдөр ТУЗ-ийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх дэд хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон:

а. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын хороог Хитоши Тани, Жэймс Пассин, Д.Амгаланбаяр гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Хитоши Тани-г томилсон.

б. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшуулалын хороог Н.Батгэрэл, Б.Амарсанаа, Д.Амгаланбаяр гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Н.Батгэрэл-г томилсон.

с. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог Д.Даянбилгүүн, Б.Энхбаяр, Филип Кури гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Д.Даянбилгүүн-г томилсон.

2015 онд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гарган баталж, 8 удаа ирц бүрдүүлэн хуралдаж ХЭХ-аас гаргасан тогтоол шийдвэрийн дагуу 11 асуудал хэлэлцэж нийт хэлэлцсэн асуудлаар 11 тогтоол, 1 тэмдэглэл гарган баталж, гүйцэтгэлд хяналт тавьж дүгнэж ажилласан.

7. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН:

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


БидиСЕК ҮЦК хувьцаат компанийн үйл ажиллагаа Монгол Улсад Хөрөнгийн Зах Зээл үүссэн 1991 онд эхэлсэн бөгөөд өнөөг хүртэл нийт 200 гаруй мянган харилцагчидтай болсон.

Бид Монголын Хөрөнгийн Зах Зээл дээр Андеррайтер, Брокер, Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг гадаад дотоодын харилцагчид, түнш байгууллагууддаа цогцоор нь чанарын өндөр түвшинд үзүүлж урт хугацааны итгэлтэй түншлэлийн харилцааг эрхэмлэн ажиллаж ирсний үр дүнд дотоодын хөрөнгийн зах зээлийн тэргүүлэгч компани болж чадсан.

Мөн Монгол Улсын эдийн засаг, салбаруудын хөгжил дэвшилд багагүй хувь нэмэр оруулсаар ирсэн ба Андеррайтерийн үйлчилгээгээрээ дамжуулан металлургын салбарт анхны төмрийн үйлдвэр, аялал жуулчлалын салбарт томоохон цогцолбор, нүүрс боловсруулах салбарт хагас коксын үйлдвэр, хаягдал тос боловсруулах үйлдвэр, уул уурхайн салбарт нүүрсний уурхай, мал аж ахуйн салбарт боловсруулах үйлдвэрийн санхүүжилт, дэд бүтэц, тээврийн салбарт ачаа шилжүүлэн ачих терминалын санхүүжилт зэрэг олон чухал төслийн хөрөнгө оруулалтыг хөрөнгийн зах зээлээс босгосон.

2008 оноос эхлэн ТУЗ-ийн гишүүнээр АНУ, Их Британ, Япон улсын олон улсад нэр хүндтэй томоохон компаниудын удирдлага, хөрөнгө оруулагчдын төлөөлөгчид сонгогдсон бөгөөд энэ онд нийт 4 хараат бус гишүүнтэйгээр компанийн засаглалын зохистой харьцааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Эрхэм зорилго:

Үндэсний үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн цогц үйлчилгээгээр дэмжих, олон улсын стандартанд нийцсэн, санхүүгийн зах зээлд тэргүүлэгч байгууллага болох.

Урт хугацаанд:

Олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулах, Үндэсний томоохон хувьцаат компаниудыг шинээр бий болгох

Дунд хугацаанд:

Үндэсний томоохон үйлдвэрлэгчдийг дэмжих, Олон улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулах, МХЗЗ-д оролцогчдын хүрээг нэмэгдүүлэх

Богино хугацаанд:

Гадаад харилцааг өргөжүүлэх, Үнэт цаасны арилжааг идэвхжүүлэх, Компанийн боловсон хүчнийг чадваржуулах, Харилцагчдыг ХХЗ-н мэдээгээр найдвартай хангах



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Манай компанийн ТУЗ-д гадаад, дотоодын нэр хүнд бүхий томоохон компаниудын удирдлагууд, хөрөнгө оруулагчид сонгогдон, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2016 онд амжилттай ажилласан.

ЕРДИЙН ГИШҮҮД



Бүрэнмэнд ЛХАГВАДОРЖ
Тэргүүн дэд захирал,
БидиСЕК ҮЦК ХК

- Иргэний харъяалал Монгол
- Төрсөн он 1976
- Боловсрол: Дээд, Нефтийн инженер мэргэжилтэй
- ХЗЗ-д 15 жил ажилласан туршлагатай.



Данзан ДАЯНБИЛГҮҮН
Гүйцэтгэх захирал,
БидиСЕК ҮЦК ХК

- Иргэний харъяалал Монгол
- Төрсөн он 1976
- Боловсрол: Дээд Бизнесийн эдийн засагч мэргэжилтэй, MBA, санхүүгийн зах зээлд 16 жил ажилласан туршлагатай.



ЖЕЙМС Пассин
Захирал, Портфель менежер Firebird Managment ХХК

- Иргэний харъяалал АНУ Нью-Йорк хот
- Төрсөн он 1971
- Боловсрол: Эдийн засагч мэргэжилтэй
- ОУ-ын ХЗЗ-д ажилласан туршлагатай.



Нарангэрэл БАТГЭРЭЛ
Дэд захирал,
БидиСЕК ҮЦК ХК

- Иргэний харъяалал, Монгол
- Төрсөн он, 1974
- Боловсрол, Олон улсын харилцааны дээд сургуулийг гадаад албаны ажилтан мэргэжлээр төгссөн.
- ХЗЗ-д 16 жил ажилласан туршлагатай



Philip Houry
Impera Capital ХХК,
Istanbul - Захирал

- Иргэний харъяалал Их Британи
- Төрсөн он – 1969
- Боловсрол дээд

ХАРААТ БУС ГИШҮҮД



ХИТОШИ Тана
Ерөнхийлөгч EXE
корпораци

- Иргэний харъяалал Япон
- Төрсөн он 1954
- Боловсрол: Дээд Эдийн засагч



Дарамранз АМГАЛАНБАЯР
Захиргааны мэргэжилтэн
MSM ХХК

- Иргэний харъяалал Монгол
- Төрсөн он 1975
- Боловсрол: Дээд Эдийн засагч мэргэжилтэй.
- ХЗЗ, уул уурхай, худалдааны салбарт ажилласан туршлагатай.



Балжинням АМАРСАНАА
Захирал, ХЭРЭЭЖИ ХХК

- Иргэний харъяалал Монгол
- Төрсөн огноо 1977
- Олон улсын харилцаа гадаад албаны ажилтан мэргэжлээр төгссөн.
- Маркетингийн чиглэлээр ажилласан туршлагатай.



Б. ЭНХБАЯР
Гүйцэтгэх захирал,
Санаа EXE групп



- Иргэний харъяалал Монгол
- Төрсөн он 1980
- Боловсрол: Дээд Эдийн засагч хөрөнгийн зах зээл, санхүүгийн чиглэлээр ажилласан туршлагатай.

ҮЙЛ АЖИЛЛАГАА

БРОКЕР, ДИЛЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2016 онд МХБ дээр нийт 416.7 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн ба үүнээс 136.2 тэрбум төгрөгийн арилжаа буюу 32.7% -ийг “БиДиСек ҮЦК” ХК хийж гүйцэтгэсэн байна.


ХУВЬЦААНЫ АРИЛЖАА



ХАРИЛЦАГЧ


2016 онд нийт харилцагчдын тоог 12,539-аар нэмэгдүүлсэн ба энэ нь өмнөх оноос 8 дахин өссөн дүн байна. Ингэснээр нийт харилцагчдын тоо 200,000-д хүрлээ.

Харилцагчиддаа Худалдаа хөгжлийн банк, ХАС банк, ХААН банк, ГОЛОМТ банк гэсэн дөрвөн settlement банкыг сонгон үйлчлүүлэх боломж олгосон цорын ганц үнэт цаасны компани болж байна.



БОНДЫН АРИЛЖАА

2016 онд МХБ дээр нийт 112.7 тэрбум төгрөгийн бондын арилжаа хийгдсэн ба үүнээс 69.6 тэрбум төгрөгийн арилжаа буюу 62% -ийг “БиДиСек ҮЦК” ХК хийж гүйцэтгэсэн байна.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ, СУДАЛГАА, АНАЛИЗ

Манай үйл ажиллагааны гол зорилтот ажлуудын нэг болох хөрөнгийн оруулалтын зөвлөх, судалгаа, шинжилгээний ажлууд маань сүүлийн жилүүдэд амжилттай явагдаж байна.

Бид судалгаа, шинжилгээ, зөвлөхийн ажлуудыг монголын хэвлэл мэдээллийн хэрэгслээр тавьж эхэлснээс хойш дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтанд голлох нөлөө үзүүлж байгаа нь өмнөх жилүүдээс харагдаж эхэлсэн.

Түүнчлэн дотоодын болон гадаадын томоохон харилцагчдаас гадна зохицуулах байгууллагууд манай судалгаа шинжилгээний ажлыг үнэлж байгаа нь тодорхой жишээнүүдээс харагдаж байгаа бөгөөд 2016 онд дараах гол судалгаануудыг гаргасан. Үүнд:

Oyu Tolgoi De-Risked 1st World Rules with Frontier Market Update - May 09, 2016

The South Gobi Land Grab - June 09, 2016

Mongolian on Cusp of 6th Bailout – Is the Sky is Falling? Sep 6, 2016

Mongolia Rising From the Ashes Riding a Wave of Coal Oct 29

MNT Finally backed by BoP, thanks to soaring export revenues

Other: Daily, Mongolia Stocks to Watch 2016 etc




Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний гэрээг дараах компаниудтай байгуулсан:

Баян тээг ХК,
 Хорго хайрхан ХК,
 Хөх ган ХК,
 Э-Транс Ложистикс ХК,
 Хөнгөн Бетон ХК



АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2016 онд Хөрөнгө оруулалтын алба 33 төсөл, 3-н тендерийн сонгон шалгаруулалтанд орж ажилласан байна.



33
Хөрөнгө оруулалтын албаны ажилласан төслийн тоо

60%
Шалгуур үзүүлэлтийг хангаагүй буцаасан болон хангасан боловч амжилттай хэрэгжээгүй төсөл

10%
Хамтран ажиллах санал тавьсан ч ирүүлээгүй төсөл

30%
Хэрэгжүүлэхээр ажиллаж буй төсөл

Уг 33 төслөөс дараах төслүүд дээр ажиллаж байна. Үүнд:


 АИС төсөл	 Шунхлай групп ХХК	 Onefit	 Цасода Пластик ХХК
Хаалттай бонд Андеррайтер гэрээ 2016	M&A Андеррайтер гэрээ 2016	Хөрөнгө оруулалт 130 сая төгрөг Хувьцаа 2016	Татан төвлөрүүлсэн хөрөнгө 1 тэрбум төгрөг Хувьцаа, Зээл 2016

2016 онд Дулааны цахилгаан станц-4 ТӨХК, Дулааны цахилгаан станц-3 ТӨХК, Шивээ овоо ХК зэрэг компаниудаас зарласан тендерт оролцсон.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

- БидиСЕК болон SAXO банк нь стратегийн түншүүд бөгөөд дотоодын харилцагчдыг Олон Улсын зах зээлд хөл тавьж, амжилттай хөрөнгө оруулалт хийхэд нь туслах үүднээс “Act Locally-Trade globally -Fin Tech is the future!” семинар уулзалтыг 2016.5.11-ний өдөр амжилттай зохион байгууллаа.
- Цахим технологийн Эн Экс Ти ХХК-ийн /Onefit/ төслийн хөрөнгө оруулалт.
- Туркойс Финанс ББСБ-д 121,7 сая төгрөгийн нэмэлт хөрөнгө оруулалт.
- ESOP хөтөлбөрийн хэрэгжилт.
- Улсад 135,8 сая төгрөгийн татвар болон 119,2 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн.







САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ХӨРӨНГӨ

ХӨРӨНГӨ БҮРЭЛДЭХҮҮН

Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/



Тайлант жилд компанийн нийт хөрөнгө 14,7 тэрбум төгрөг ба үүнээс 62 хувийг эргэлтийн хөрөнгө, 38 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзлэж байна. Нийт хөрөнгөнд эзлэх эргэлтийн хөрөнгийн хэмжээ 62% байгаа нь хангалттай сайн үзүүлэлттэй байгааг илтгэж байна.

Эргэлтийн хөрөнгө ба богино хугацаат хөрөнгө оруулалт /сая төгрөг/




Эргэлтийн бус хөрөнгө, түүний бүтэц /сая төгрөг/




ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ

Хөрөнгийн эх үүсвэрийн бүрэлдэхүүн /сая төгрөг/



Эх үүсвэрийн бүтцэд өр төлбөр 40%, эзэмшигчийн өмч 60% байвал санхүүгийн хувьд эрсдэлгүй харьцаа гэж тооцдог бөгөөд манай компанийн хувьд 2015 оны байдлаар өр төлбөр 1%, эзэмшигчийн өмч 99%-ийг эзлэж байгаа нь хангалттай сайн үзүүлэлт юм.

ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГ




- Цэвэр ашиг
- Нийт зардал
- Нийт орлого

САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ

Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ

Шинжилгээ	2012	2013	2014	2015	2016
Бие даах чадварын коэффициент	97,12%	91,45%	89,55%	96,94%	98,79%
Зохицуулалтын коэффициент	60,91%	61,19%	70,50%	57,46%	61,91%



Зохицуулалтын коэффициент нь өөрийн капиталын эргэлтийн хэсэгт ногдох хувийг харуулдаг. Энэ үзүүлэлт тогтмол өндөр байгаа нь компанийн үйл ажиллагаа тогтвортой, бие даан үйл ажиллагаа явуулах чадвар өндөр байгааг харуулж байна.

■ Бие даах чадварын коэффициент
 ■ Зохицуулалтын коэффициент

Зах зээлийн идэвхжилийн шинжилгээ

Шинжилгээ	2012	2013	2014	2015	2016
Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS)	135.6	26.2	(36.0)	1.45	(51.9)
Зах зээлийн үнэ ба бүртгэлийн үнийн харьцаа (ЗЗҮ/БҮ)	4.2	3.0	2.3	1.5	15.1
Үнэ ашгийн харьцаа (P/E)	26.6	91.7	n/a	1.16	n/a

EPS буюу нэгж хувьцаанд ногдох ашиг гэдэг нь компанийн нэгж хувьцааны цаана хэдэн төгрөгний ашиг олж байгааг харуулдаг.

ЗЗҮ/БҮ нь тухайн нэгж хувьцаанд ногдох бодит хөрөнгийн бүртгэлийн үнээс давуулж төлсөн үнэ буюу хөрөнгө оруулагчдын зүгээс компанийн ирээдүйд хэр итгэж байгааг харуулдаг чухал үзүүлэлт юм.

P/E буюу үнэ ашгийн харьцаа нь тухайн хувьцааны үнэ зах зээл дээр хэр бодитой үнэлэгдэж байгааг тодорхойлдог үзүүлэлт юм.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД

Бид 2016 оны 12 дугаар сарын 31-ээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “БиДиСек ҮЦК” ХК болон түүний охин компаниудын нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр Би Ди Сек ҮЦК ХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага нэгтгэсэн санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу “Би Ди Сек ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээнд зориулан бэлтгэсэн бөгөөд бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.



ДАЛАЙВАН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2017 ОНЫ 02 ДҮГЭЭР
САРЫН 10-НЫ ӨДӨР

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31

Монгол төгрөгөөр/

Үзүүлэлт	Тадруулга	2016.12.31	2015.12.31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4	166,312.2	66,428.0
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгө	5	6,384,626.4	7,350,636.0
Борлуулгахад бэлэн санхүүгийн хөрөнгө	10	1,046,616.5	-
Худалданы ба бусад аялага	6	1,500,065.5	1,538,602.0
Борлуулах зорилгоор хэмшиж буй хөрөнгө	7	70,780.5	263,003.0
Эргэлтийн хөрөнгийн дүн		9,168,401.1	9,218,669.0
Эргэлтийн бус хөрөнгө			
Өмч, барилга, тэнэг тохоромж - цэвэр	8	5,447,126.6	5,608,751.0
Бяет бус хөрөнгө - цэвэр	9	5,395.2	6,628.0
Өмчөөр тайлагнагдах хариат компанид оруулсан хөрөнгө оруулалт	10	1,000.0	768,014.0
Урт хугацаат аялага	11	102,491.7	114,460.0
Хойшлогдсон татварын хөрөнгө	12	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		5,556,013.5	6,497,853.0
НИЙТ ХӨРӨНГӨ		14,724,414.6	15,716,522.0
ӨР ТӨЛБӨР			
Богшино хугацаат өр төлбөр			
Худалданы ба бусад өглөг	13	118,395.3	87,804.0
Банкны богшино хугацаат зээл	14	-	320,000.0
Орлогын албан татварын өглөг	15	793.6	-
Бусад татварын өглөг	15	19,011.4	33,724.0
Нэгдэл ашгийн өглөг		-	-
Богшино хугацаат төлбөрийн дүн		138,200.3	441,528.0
Урт хугацаат өр төлбөр			
Хойшлогдсон татварын өглөг		-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		-	-
Нийт өр төлбөр		138,200.3	441,528.0
ӨМЧ			
Хувьцаат капитал	16	9,326,797.6	8,821,422.0
Дамхи үнэлгээний нэмэгдэл	16	3,824,524.4	3,824,524.0
Борлуулгахад бэлэн хөрөнгө оруулалтын хэрэгжээгүй хуримтлагдсан олоо(гарз)		-	-
Хуримтлагдсан ашиг	16	1,434,892.3	2,629,049.0
Нийт өмч		14,586,214.3	15,274,995.0
НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		14,724,414.6	15,716,522.0

"DALANJA AUDIT" Co., Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

"БИДИ СЕК ҮЦК" ХК-ийн 2016 оны 12-р сарын 31-нхэр төгсгөл бэлтгэсэн
 НЭГТГЭСЭН САХУУТГИЙН ТАЙЛАН

НЭГТГЭСЭН АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
 2016 оны 12 дугаар сарын 31

(Мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Тодруулга	2016.12.31	2015.12.31
Үндсэн үйл ажиллагааны орлого	17	879,635.7	797,159.0
Бусад үйл ажиллагааны орлого	18	121,215.0	121,485.0
Үйл ажиллагааны зардал	19	(1,501,327.4)	(1,316,319.0)
Үйл ажиллагааны алдагдал		(500,476.7)	(397,675.0)
Санхүүгийн орлого	20	529,962.9	515,541.0
Санхүүгийн зардал	21	(756,949.5)	(98,323.0)
Өмчөөр тайлагнагдах хараат компанийн цэвэр ашигын ногдох хувь	22	107,930.5	32,015.0
Үйл ажиллагааны бус орлого/(зардал)	23	(85,915.9)	(25,088.0)
Татвар төлөхийн өмнөх ашиг/(алдагдал)		(705,448.7)	26,470.0
Орлогын татварын зардал	24	(5,065.6)	(6,946.0)
Тайлант жилийн цэвэр ашиг/(алдагдал)		(710,514.3)	19,526.0
Бусад дэлгэрэнгүй орлого:			
Ашиг, алдагдлаар дахин ангилагдахгүй зүйлс:			
Дахин үнэлгээний нөмөгдөл		-	2,524,279.0
Ашиг, алдагдлаар дахин ангилагдах зүйлс:			2,524,279.0
Богшино хугацаат хөрөнгө оруулалтын хэрэгжээгүй ош/(гара)		-	-
Хэрэгжээгүй ошод ногдох хайшлагдсон татвар		-	-
			-
Бусад дэлгэрэнгүй орлого		-	2,524,279.0
Нийт дэлгэрэнгүй орлого/(зардал)		-	2,543,805.0
Нэгж хувьцаанд ногдох ашиг/(алдагдал)			
Суурь (тогрөг)	25	(51.88)	1.45

«БИДИ СЕК ҮЦК» ХК-ийн
 CERTIFIED ACCOUNTING, AUDITING
 & APPRAISAL

НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Нэмж тологдсон капитал	Дахин үргэлжлэлийн бөөм	Үзэг цалины хэрэгжээгүй олиг(гар)	Хуримтлагдсан ашиг	Нийт өмч
2015 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	1,347,734.6	7,473,282.9	1,300,244.4	390,360.0	2,677,381.0	13,189,002.9
Гаргасан хувьцаа	19.0					19.0
Нэмж тологдсон капитал		386.0				386.0
Дахин үргэлжлэлий нэмэгдэл			2,524,280.0			2,524,280.0
Орлогын тайланд хүтээн зөвшөөрөөгүй олиг(гар)				(390,360.0)		(390,360.0)
Хуваарилсан ногдол ашиг					19,526.0	19,526.0
Тайлант жилийн цэвэр ашиг					(67,860.0)	(67,860.0)
Залруулга						
2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,347,753.6	7,473,668.9	3,824,524.4	-	2,629,047.0	15,274,993.9
Гаргасан хувьцаа	21,734.7					21,734.7
Нэмж тологдсон капитал		483,640.4				483,640.4
Дахин үргэлжлэлий нэмэгдэл						
Орлогын тайланд хүтээн зөвшөөрөөгүй олиг(гар)					(710,514.3)	(710,514.3)
Хуваарилсан ногдол ашиг					(483,640.4)	(483,640.4)
Тайлант жилийн цэвэр ашиг						
Залруулга						
2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,369,488.3	7,957,309.3	3,824,524.4	-	1,434,892.3	14,586,214.3

"DALAIAN AUDIT" Co., Ltd

CERTIFIED ACCOUNTING AUDITING

Б. А. П. Ц. А. Л. А. Н.

"БидиСЕК ҮЦК ХК"-ийн 2016 оны 12-р сарын 31-нээр төсөлбэр болгосон
 НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31

Монгол төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2016.12.31	2015.12.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<i>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн орлого</i>	<i>1,562,013.7</i>	<i>1,257,949.2</i>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,148,032.2	1,255,873.2
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Бусад орлого	413,981.5	2,076.0
<i>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн зардал</i>	<i>1,146,509.5</i>	<i>1,201,209.2</i>
Хөрнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Ажиллагсдад төлсөн мөнгө	636,925.4	599,794.4
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	117,681.6	114,927.9
Түүхий эд, материал худалдан авахад төлсөн	12,238.1	45,454.6
Ашигласны зардалд төлсөн	123,776.9	47,554.0
Түшиг шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн	27,399.7	24,347.6
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	-	219.1
Хүүний төлбөрт төлсөн	27,859.1	25,071.3
Татварын байгууллагад төлсөн	22,294.3	70,961.0
Шимтгэл хураамжид төлсөн	36,805.0	-
Даатгалын төлбөрт төлсөн	2,224.8	-
Бусад мөнгөн зарлага	139,304.6	272,879.3
<i>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйцээ</i>	<i>415,504.2</i>	<i>56,740.0</i>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<i>Мөнгөн орлогын дүн</i>	<i>493,178.4</i>	<i>1,340,205.0</i>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	65,740.0	-
Биег бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	427,438.4	1,340,205.0
<i>Мөнгөн зарлагын дүн</i>	<i>552,971.9</i>	<i>5,636,750.1</i>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,410.0	13,241.5
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	549,561.9	5,623,508.6
<i>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйцээ</i>	<i>(59,793.5)</i>	<i>(4,296,545.1)</i>
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<i>Мөнгөн орлогын дүн</i>	<i>84,963.5</i>	<i>457,989.0</i>
Эзэл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	39,507.2	397,590.0
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	18.9
Бусад мөнгөн орлого	45,456.3	60,380.1
<i>Мөнгөн зарлагын дүн</i>	<i>348,320.0</i>	<i>1,292,418.2</i>
Эзэл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	348,320.0	779,690.0
Төлсөн ногдол ашиг	-	512,728.2
<i>Санхүүгийн цэвэр мөнгөн гүйцээ</i>	<i>(263,356.5)</i>	<i>(834,429.2)</i>
Валютын ханшийн зөрүү	7,530.4	20,775.8
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	99,884.6	(5,053,458.5)
Мөнгө, түүвтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	66,427.6	5,119,886.1
Мөнгө, түүвтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	166,312.2	66,427.6

"БидиСЕК ҮЦК ХК" ОУХ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Компани нь Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, иргэдийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх, мэргэжлийн байгууллага, холбоодын үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжируулахад анхаарч ажилласаар ирлээ.

Мөн өөрийн орны хүрээлэн буй орчныг хамгаалах, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ, соёл урлаг болон оюутан залуучуудын гаргасан шинэлэг санал, санаачлагыг бүхий л талаар дэмжиж, хамтран ажилласан.

БОЛОВСРОЛ

Хөрөнгийн зах зээлийн анхан шатны мэдлэгийг хүргэх үүднээс “I Like Mongolian Capital Market” аяныг санаачлан, зохион байгуулж. Энэ аяны хүрээг жил бүр өргөжүүлэн Аж ахуйн нэгж байгуулагуудад анхан шатны мэдлэг олгох сургалтыг өөрийн боловсон хүчин, материаллаг бааз дээрээ тулгуурлан орон нутгийн салбаруудаар дамжуулан 9 дэх жилдээ амжилттай зохион байгуулж нийт 10,000 гаруй хүмүүсийг хамруулаад байна.

Оюутан сурагчдын сурч мэдэх хүсэл эрэмзлэл, гаргасан аливаа шинэлэг санал, санаачлагыг хөхүүлэн дэмжиж тэдэнтэй нягт холбоотой хамтран ажиллаж байна.

Market Watch өөрийн компанид жижиг студийг бий болгож хөрөнгийн зах зээлийн шинэлэг мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэж байна.

НИЙГЭМД ЧИГЛЭГДСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙГ ДЭМЖИГЧ

Байгаль орчинд ээлтэй үндэсний үйлдвэрлэлүүдийн томоохон төсөл, хөтөлбөрийг дэмжиж тэдэнд шаардлагатай санхүүгийн үйлчилгээг үзүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдын хоорондын уялдаа холбоог сайжируулах ажлуудыг жил бүр хийдэг.

Байгууллага хамт олноороо Мод тарих өдрөөр Мөрөөдлийн цэцэрлэгт хүрээлэнд мод тарьсан.

Цаашид байгаль орчинд болоод цэвэр үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтрүүлэгч байгууллага, иргэдтэй хамтран ажиллах хөтөлбөрийг шат дараатайгаар хэрэгжүүлж байна.



ХАРИЛЦАГЧДАД

Харилцагчдаа стандартын шаардлага хангасан ая тухтай, тохилог орчинд үйлчлүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх тэдний хэрэгцээ шаардлагыг хангасан өндөр түвшиний үйлчилгээг үзүүлэхээр ажиллаж байна.

Хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчдыг жил бүр тухайн хөрөнгө оруулсан хувьцаат компаниудтай танилцах аялалыг зохион байгуулж үйл ажиллагаа, үр дүн цаашид хийх ажлын төлөвлөгөөтэй танилцуулдаг.

Харилцагч, хөрөнгө оруулагч нарт шийдвэр гаргахад нь тус дөхөм болох зорилгоор бүртгэлтэй компаниудыг анх удаа нээлттэй байдал, хувьцаа эзэмшигчдийн эрх ашигийг хамгаалдаг байдал, ирээдүйн боломж, санхүүгийн үзүүлэлт зэрэг шалгуурууд дээр тулгуурлан стандартчиллыг хийдэг.

УРЛАГ, СПОРТ, АЯЛАЛ

Хөрөнгийн зах зээл дээр ажилладаг мэргэжлийн байгууллагуудын дунд найрсаг харилцаа, халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэх, тэдгээрийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор өөрийн нэрэмжит BDS CUP 2016“ хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг Gobi Deluxe Hotel & Resort амралтын газар болон Onefit төслийг хэрэгжүүлэгч Эн Экс Ти ХХК ивээн тэтгэж 10 дахь жилдээ амжилттай зохион байгуулж, Зохион байгуулагч БидиСек ХК “аваргын цом“-ыг хүртлээ.

ХҮНИЙ НӨӨЦ

Мэргэжилтэнүүдийг мэргэшүүлэх сургалтуудад хамруулахаас гадна амралт, чөлөөт цагийг ая тухтай байлгах, байгалын үзэсгэлэнт газруудаар аялуулах, амраах зорилгоор “Tour de Baikal” “Аглаг бүтээлийн хийд” зэрэг аяллыг зохион байгуулсан.



III. ТАЙЛАНГИЙН ГУРАВДАХЬ ХЭСЭГ

Компани нь 2016 оны 4 сарын 25-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

- a. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
- b. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах
- c. Компани ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг хэлэлцэж батлах
- d. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- e. ТУЗ-ийн 2016 оны төсөв батлах
- f. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай
- g. Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоог тогтоох тухай

Компани нь 2015 оны 3 сарын 26-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

- a. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
- b. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах
- c. Компани нь ногдол ашиг тараах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэж батлах
- d. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- e. ТУЗ-ийн 2015 оны төсөв батлах
- f. Компанийн нэрэнд өөрчлөлт оруулах тухай
- g. Нэмэлт хувьцааны арилжааны тайланг тайланг хэлэлцэх
- h. Шинээр татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй холбоотойгоор бизнес төлөвлөгөө, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тодотголыг танилцуулах
- i. Үнэт цаасны танилцуулгын өөрчлөлтийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулах
- j. Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоог тогтоох тухай
- k. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Компани нь 2014 оны 04 сарын 18-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.

- a. Компанийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийн талаар ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан
- b. ТУЗ-ийн ногол ашиг тараах эсэх талаар гаргасан шийдвэрийг хэлэлцэж батлах
- c. Нэмэлт хувьцааны тоог шинэчлэн тогтоох тухай
- d. Компанийн 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
- e. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- f. ТУЗ-ийн 2014 оны цалин урамшуулалын төсөв батлах

▶ ХОЛБОО БАРИХ:



Дэд захирал
Н.Батгэрэл



Менежер
Г.Мөнхтулга

ТӨВ ОФФИС

Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Залуучуудын өргөн чөлөө 27/1
БиДиСЕК ҮЦК ХК

Утас/Факс: (976)-11-313108, (976)-
11-323411

Цахим хуудас: www.bdsec.mn

Цахим шуудан: info@bdsec.mn

ОРХОН-УУЛ САЛБАР

Орхон-Уул аймаг, Баян-Өндөр сум,
Хүрэн булаг баг, Харх ХХК-ийн
байр 301 тоот

Утас: (976)-70358318, (976)-
99072846

Цахим шуудан: erdenet@bdsec.mn

ТӨВ АЙМАГ САЛБАР

Төв аймаг, Зуун мод хот
“Монгол даатгал” ХХК-ийн байр 203
тоот

Утас: (976)-99043165

Цахим шуудан: clients@bdsec.mn

ДАРХАН- УУЛ САЛБАР

Дархан-Уул аймаг, Дархан сум
Дархан их дэлгүүрийн 6 давхарт

Цахим шуудан: darkhan@bdsec.mn

Утас: (976)-99902876

ТУЗ-ийн нарийн бичгийн
дарга Ө.Даваасүрэн